

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2026 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын нэр:	Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал		
Огноо:	2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр 11:00-14:20	Уулзалтын газар:	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн хурлын заал
Хурлын дарга:	Гомбосүрэнгийн Болдсайхан, МЦХ ХК-ийн Дотоод аудитын газрын захирал		
Тооллогын комисс:	Дарга: Т.Бямбасүрэн, Бодлого төлөвлөлтийн албаны ерөнхий менежер, Гишүүд: Б.Дагвадорж, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер, Э.Булганчимэг, ИБХГ-ын техник төлөвлөлтийн мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комисс:	Дарга: Ч.Цогтгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын захирал Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Батнасан, Удирдлага хүний нөөцийн газрын мэргэжилтэн		
Ирц:	Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276 ширхэг. Үүнээс нийт 24,500,756 ширхэг саналын эрх бүхий 21 хувьцаа эзэмшигч оролцож ирц 94.71%		

ХЭЛЭЛЦСЭН нь:

- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай, Үүнд:
 - 1.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай
 - 1.3. Ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай
 - 1.4. Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай
 - 1.5. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах тухай
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай;

СОНССОН нь:

Т.Бямбасүрэн, Тооллогын комиссын дарга: 1. Компанийн тухай хуулийн 69.1-д “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно”; 2. МЦХ ХК-ийн дүрмийн 7.12-д “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 61-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүртгэхэд нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 24,500,756 ширхэг хувьцаа эзэмшиж буй 21 хувьцаа эзэмшигч ирж 94.71 хувийн ирцтэй байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна.

Г.Болдсайхан, хурлын дарга: Ирц бүрдэж, хурлын үйл ажиллагаа хүчин төгөлдөр болсон учраас Монголын цахилгаан холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээснийг мэдэгдье. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол танилцуулъя.

Хурлын дарга Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулж, хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлаар танилцуулга хийх илтгэгчдийг индэрт урьж, танилцуулга хийлээ. Үүнд:

Нэгдүгээр хэлэлцэх асуудлаар

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Хэлэлцсэн асуудлаар дараах танилцуулгуудыг хийв.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Чинбат компанийн жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ танилцуулав.

2024 оны ногдол ашиг тараасан тайланг Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Н.Мягмарсүрэн танилцуулав.

Компанийн 2025 оны санхүүгийн аудитын тайланг Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Н.Мягмарсүрэн танилцуулав.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хараат бус гишүүн Х.Баянбай, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа нар танилцуулав.

Хоёрдугаар хэлэлцэх асуудлаар

2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах тухай

Хэлэлцэх асуудлаар ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг МЦХ ХК-ийн Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Н.Мягмарсүрэн танилцууллаа.

Гуравдугаар хэлэлцэх асуудлаар

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;

Хэлэлцэх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны тогтоол, нэр дэвшигчдийн танилцуулгыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа танилцууллаа.

Дөрөвдүгээр хэлэлцэх асуудлаар

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай;

Хэлэлцэх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийн төслийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа танилцууллаа.

Г.Болдсайхан, хурлын дарга: Танилцуулагдсан асуудлуудтай холбоотой асуулт, хариултын цаг эхэлж байна. Гучин минут байгаа, Асуулттай хувьцаа эзэмшигч байвал асуултаа асууна уу.

Асуулт хариулт, санал:

Сайн-Ерөөлт, хувьцаа эзэмшигч: Хурлын зар яаж хүргэдэг вэ, хувьцаа эзэмшигчдийн цуглаж байгаа байдал нь нэлээн цөөхөн, 3,000 гаруй Монгол Улсад байгаа. Сүүлийн хэдэн жил сууж байна, хувьцаа эзэмшигчид хуралдаа суухгүй байна. Арван жилийн хүүхдийн эцэг эхийн хурал шиг тав, аравхан хүн л сууж байна. Би бол нэг хүний амнаас ам дамжин л сонсож байна. Зар яаж яваад байна.

Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга: Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг СЗХ, МХБ-ээс гаргасан журмын дагуу зарыг явуулдаг. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар жил бүрийн 3 сарын 21-ний дотор гардаг. Зарыг манай компани хамгийн олон мэдээллийн сувгаар тараадаг. Хоёр өдөр тутмын сониноор, ТВ-ээр, компанийн вэб сайтаар, Монголын хөрөнгийн биржийн вэб сайтаар, хараат бусын зарыг ТӨБЗГ-ын вэб сайтаар зарладаг. Мөн toim.mn, компанийн Фэйсбүүк хуудсаар хууль, журмын дагуу зарласан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг мэдээллийг байж болох бүх сувгуудаар тараасан учраас мэдээлэл авч байгаа асуудал нь тухайн хувьцаа эзэмшигчийн өөрийнх нь эрхийн асуудал байгаа. Бүртгэлтэй компаниудад хүргүүлэх асуудлыг брокер дилерийн компаниуд хийдэг бол Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг гаргаж өгөхдөө хувь хүний мэдээллийн нууцтай холбоотой утасны дугаарыг гаргаж өгдөггүй байгаа. Хоёрдугаарт нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хувьд 70 ширхэг хувьцаа авсан компанийн ажилчид зэрэг идэвхгүй хувьцаа эзэмшигчид маш их байдаг. Магадгүй хувьцаа эзэмшигчдийн хурал оролцож байгаа тоо нь тухайн идэвхгүй хувьцаа эзэмшигчидтэй маань холбоотой байдаг болов уу.

Сайн-Ерөөлт, хувьцаа эзэмшигч: Цөөхөн хүн ирээд, нөгөө л байдаг хүмүүс нь байгаад байна.

Ц.Шинэхүү, төрийн өмчийн төлөөлөл: Хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүдийг хэлж байх шиг байна. Одоо байгаа ТУЗ-ийн гишүүдийг өөрчлөх асуудал явагдаж байгаа. Хараат бус 5 гишүүнээс 3-ыг сонгох ёстой. Мэдээж тухайн компанийн санхүү, эдийн засаг хамгийн өндөр оноо авсан хүн ТУЗ гишүүн болохгүй ээ гэдгийг хэлье. Ер нь бол төрийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа 6 гишүүнд тодорхой хэмжээний өөрчлөлт явагдана гэж ойлгож болно.

Ц.Баяр-Эрдэнэ, ТУЗ-ийн дарга: Өнгөрсөн хугацаанд компанийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн дарга гэдэг үүрэгт ажлыг хариуцаж бодлого чиглэлд нь оролцож ирсэн. Чинбат захирал өөрийн хүсэлтээр ажлаа өгнө гэсэн мэдэгдэл хийсэн. Төрийн өмчийн төлөөллийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гадна Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр, дүрэмд заасан хүрээнд чөлөөлөөд явах бололцоотой байгаа. Би сүүлийн хугацаанд компанийн багт ТУЗ-ийн багт Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллахдаа нэлээн чамгүй хичээсэн гэж өөрийгөө бодож байгаа. Гэхдээ энэ удаад цаашид Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах эрхгүй гэж өөрийгөө үзэж байгаа. Яагаад гэхээр хоёр, гурван ч удаа хязгаарлалттай дүгнэлт авлаа. Хэдийгээр бид зориод ажил төрлөө төлөвлөөд ажил үүргээ гүйцэтгээд явж байгаа ч гэсэн сүлжээний өргөтгөлөөс хамаараад тухайлбал өнгөрсөн онд сумдад хэрэгжих байсан хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлж чадаагүй асуудлууд гарсан. Тийм учраас би цаашид компанийн ашигт ажиллагааг сайжруулах, үнэхээр үр өгөөжийг нь нэмэгдүүлэх, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилтуудыг хэрэгжүүлэхүйц Төлөөлөн удирдах зөвлөлд шинэ хүмүүс орж ирэх ёстой гэсэн байр суурьтай байгаа гэдгийг хэлье.

Ц.Шинэхүү, төрийн өмчийн төлөөлөл: Энэ удаад төрийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа зургаан гишүүн сонгогдоод явна. Хараат бус гишүүн 5 нэр дэвшигчдээс 3 гишүүн сонгогдоно.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: Олон улсын ярианы 001 гээд гарц байдаг. Орлогын нэлээд хувийг эзэлдэг байсан. Яагаад гэхээр IP байгаагүй, одоо бол IP-д суурилж явж байгаа. Одоо энэ гарцаар ярьж байгаа орлого статистик, орлогын хувьд хэдэн хувийг эзэлж байна? Тайлангаас харахад манай компанийн хувьд бол зах зээлийн ширүүн техник үйлдвэрлэлийн үед боломжоороо л зүтгэж байгаа, ганц төрийн өмч давамгайлан компани шүү дээ. Одоогийн байдлаар 21 аймгийн 290 сумдад үйлчилгээгээ үзүүлдэг юм байна. 60 гаруй сумдад ОТТ технологийн гол сүлжээгээ хүргэсэн юм байна гэж ойлголоо. Энэ оны хувьд 9 сумдад 64 км шилэн кабель суурилуулж, зарим сумдад WiFi оруулсан дэвшилттэй байна. Суурин утас хувьд ХХЗХ-ны статистик мэдээгээр 3-р байранд 5.3 хувийн эзэлдэг гэсэн байна. Интернэтийн үйлчилгээгээр тодорхой хувийг эзэлж байгаа байх. Үйлчилгээгээ өргөтгөх талаар ажиллах хэрэгтэй. Үйлчилгээгээ өргөтгөх талаар би нэг санал хэлье. Хандалтын сүлжээг өргөжүүлэх нөхцөл боломжтой гэж харж байгаа. Үйлчлэгч байгууллагад техникийн нөхцөл өгөөд өргөтгөх талааж ажилла. Улаанбаатар хотод шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж зөндөө байгаа. MSAN очсон газар болгонд хуваарилах шүүгээ, МХС-ийн шкафын хажууд шкафаа тавиад, MSAN-аа тавиад зоосон газруудынхаа байршлыг Хотын сүлжээний газрын өгөгдөлд оруулаад техникийн нөхцөл өгч байгаа ч ээ. Энэ асуудлыг шийдэж болох юм билээ. Сүлжээ өргөтгөх талаар анхаарч ажиллаа ч ээ. 2. Санхүүгийн талаар үндэсний аудитын газрын тайланд 10 гаруй жил болсон авлагыг шийдмээр байна. ТУЗ дээр ярьдаг л байх. Цэгцлээд ТУЗ-д оруулах хэрэгтэй. 3. Сонирхол татсан асуудал, ТУЗ-ийн гишүүдийн цалинг 45 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосон. 10 хуралд 100 хувийн саналтай оролцсон байна. Хурлын 8 удаа хуралдсан гэж хариуцлагагүй л гэж хэлнэ. Алдаа их байна. 4. ТУЗ-ийн ажиллагааг сайжруулаа ч ээ л гэх байна. Тайлангийн хуралд ТУЗ-ийн гишүүний хийсэн ажлын тодорхой тавиа ч ээ л гэсэн байна.

Б.Чинбат, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: Олон улсын 001 гарцын орлого 2025 онд жилийн 44 сая төгрөг байсан.

Г.Нямжав, Техник, технологийн ашиглалтын газрын захирал: Дэлхий нийтээр олон улсын яриа буурч байгаа. Тэр үед ганцхан 001 гарц байсан. Сүүлд 002, 003 гээд гарсан. Одоо хүмүүс мөнгө төлж ярихаа больсон. Гол орлого нь Корей телеком, Рос телеком харилцан холболтоос орлого олдог, алдагдалгүй ажиллаж байгаа.

Г.Болдсайхан, хурлын дарга: Өөр асуулт, саналтай хувьцаа эзэмшигч байна уу.

Г.Болдсайхан, хурлын дарга: Асуулт саналтай хүн байхгүй байна. Тооллогын комисс санал хураалтаа явуулъя.

Т.Бямбасүрэн, Тооллогын комиссын дарга: Санал хураалтын дүн, тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Санал хураалтын дүнгийн тухай:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 24,500,756 ширхэг хувьцаа эзэмшиж буй 21 хувьцаа эзэмшигч оролцож, үүнээс 20 хувьцаа эзэмшигч санал өгсөн бөгөөд хүчингүй саналын хуудас 1 байна.

Саналын хуудсанд 3 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр доорх санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд

Зөвшөөрсөн 18 санал, 99.99 хувиар буюу 24,500,535 ширхэг хувьцаа; Татгалзсан 1 санал 0.001 хувиар буюу 200 ширхэг хувьцаа.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай асуудалд

Зөвшөөрсөн 18 санал, 99.99 хувиар буюу 24,500,535 ширхэг хувьцаа; Татгалзсан 1 санал 0.001 хувиар буюу 200 ширхэг хувьцаа.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудалд гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар санал өгснөөс;

ТУЗ-ийн ердийн гишүүнд

1. А.Молор	24,500,633 кумулятив санал, 99.99 хувь;
2. Ц.Баяр-Эрдэнэ	24,500,498 кумулятив санал, 99.99 хувь;
3. Б.Төрбат	24,500,543 кумулятив санал, 99.99 хувь;
4. Д.Нарангэрэл	24,500,543 кумулятив санал, 99.99 хувь;
5. С.Ганзориг	24,500,596 кумулятив санал, 99.99 хувь;
6. Б.Билэгдэмбэрэл	24,500,443 кумулятив санал, 99.99 хувь;

ТУЗ-ийн хараат бус гишүүнд

1. Н.Туул	24,500,077 кумулятив санал, 99.99 хувь;
2. С.Цолмон	24,500,003 кумулятив санал, 99.99 хувь;
3. Х.Баянбай	345 кумулятив санал, 0.001 хувь;
4. Н.Данзандагва	24,502,068 кумулятив санал, 99.99 хувь;
5. С.Солонго	866 кумулятив санал, 0.001 хувь;

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.99 (хувь)-ийн саналаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 99.99 (хувь)-ийн саналаар тус тус баталж, кумулятив аргаар хамгийн өндөр санал авсан А.Молор, Ц.Баяр-Эрдэнэ, Б.Төрбат, Д.Нарангэрэл, С.Ганзориг, Б.Билэгдэмбэрэл нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнээр, Н.Туул, С.Цолмон, Н.Данзандагва (тус бүр 99.99%) нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгох нь зүйтэй гэж үзэв.

Хурлын дарга тооллогын комиссын тогтоолыг үндэслэн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулан хурлыг хаав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.99 хувийн

саналаар батлав.

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг тус тус зөвшөөрч батлав.

2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолтой танилцав.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов. Үүнд:

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан Н.Туул, С.Цолмон, Н.Данзандагва нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, Ц.Баяр-Эрдэнэ, Д.Нарангэрэл, Б.Төрбат, Б.Билэгдэмбэрэл, А.Молор, С.Ганзориг нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс тус тус сонгосугай.

- Х.Баянбайг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.

- Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

- Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ТАНИЛЦСАН:

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Г.БОЛДСАЙХАН, 2026 ОНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ДАРГА

Х.ЦЭЦЭГМАА, ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

2026 оны 5 дугаар сарын 01
Улаанбаатар хот.